



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/147

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын 2023 оны “Цахим аймаг” бодлогын зөвлөмж батлах тухай А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цахим аймаг” бодлого зөвлөмжийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулах “Digital first D1” арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ш.Отгон-Эрдэнэ (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Д.Баасансүрэн (Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн захирал)

Ж.Даваахүү (“Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК Хөвсгөл аймаг дахь салбарын дарга)

Д.Ундармаа (“Монголын Цахилгаан холбоо” ХК-ны Хөвсгөл аймаг дахь салбарын захирал)

Х.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

М.Мөнх-Аюуш (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ч.Хуншагай (Аймгийн Татварын хэлтсийн дарга)

Б.Батжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Г.Пунцагбалжир (Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Сумаадагва (Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

671.010439